



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Хяналтын төрийн бус байгууллага
ажиллуулах тухай


Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дахь заалт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.4, 3.1.15, 3.1.16 дэх хэсэг, 2018 оны 12 дугаар сарын 31-ний ажил дүгнэх хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын гудамж, зам талбайн хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх, хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааны өдөр тутмын хяналтыг 2019 онд төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Төрийн бус байгууллагуудын 2019 онд хяналт тавьж ажиллах нутаг дэвсгэрийн хуваарийг хавсралтаар баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Хяналтын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд 2019 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллахыг Аудит, дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т даалгасугай.

4. Хяналтын төрийн бус байгууллага ажиллуулах зардлыг 2019 оны батлагдсан Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, Гэр хорооллын айл өрхийн бие засах газар, бохирын цооног ариутгах ажил, Зуслангийн бохирын цооног, нийтийн бие засах газар, хогийн цэгийн, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, Зуслан ногоон бүсэд нийтийн бие засах газар байгуулах, Алтан өлгийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын зардал, Нийтийн бие засах газрын ашиглалтын болон ажилчдын зардлын 2%-аар тооцон тус тус санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300003

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 01 сарын 02 өдрийн А/02
тушаалын хавсралт



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН 2019 ОНД
ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ
НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРЬ

Д/д	Хяналт тавих байгууллага	Хариуцах нутаг дэвсгэр
1	"Хотын хөгжлийг дэмжих Улаанбаатар шинэ тосгон хөдөлгөөн" ТББ	Сонгинохайрхан дүүрэг Чингэлтэй дүүрэг
2	"Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ	Баянзүрх дүүрэг Хан-Уул дүүрэг
3	"Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал хөгжлийн хүрээлэн" ТББ	Баянгол дүүрэг Сүхбаатар дүүрэг